



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/330

Хэрлэн сум

Малын генетик нөөцийн төлөв байдлыг
үнэлэх, тодорхойлох ажлыг зохион байгуулах
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а", 30 дугаар зүйлийн 30.1.16, Малын генетик нөөцийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 18 дугаар зүйлийн 18.2.2 дахь заалт, Монгол Улсын Их хурлын 82 дугаар тогтоол, Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А-169 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх ажлыг орон нутагт зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий мэргэжлийн баг /ажлын хэсэг/-ийг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ж.Энх-Амгалан	-Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Г.Гантөмөр	-Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга
Гишүүд:	Н.Ган-Адъяа	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө, оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	Б.Сүнгээ	-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга
	М.Анхныбаяр	-Хүнс, Хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн/

2. Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх ажлыг удирдамж, олон улсын мэргэжлийн байгууллагын зөвлөмж, зааврыг үндэслэн орон нутагт үр дүнтэй зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Ж.Энх-Амгалан/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Б.Сүнгээ/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА